



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№07 /220/

2022.01.10

Тусгай дугаар

## БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2021 ОНЫ ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ, БҮТЭЭЛЧ АЖЛУУД

### № ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ БҮТЭЭЛЧ АЖЛУУД

1.Түүхэн ойнуудыг тэмдэглэв. Батлан хамгаалахын хууль, эрх зүйн шинэчлэл хийгдэж байна.

2.Монгол Улсын Зэвсэгт хүчин Төрийн тэргүүн зэргийн одон хүртэв. Журмууд шинэчлэгдэн батлагдлаа.

3.Төрлийн цэргийн удирдлагын байгууллагуудыг бэхжүүлээ. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний дунд хугацааны хөгжлийн стратегийн баримт бичгүүд

батлагдлаа.

4.Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаа өргөжлөө. Батлан хамгаалахын "ЦАГААН НОМ"-ыг бүтээлээ.

5.Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлын түвшинг дээшлүүлээ. Цэргийн зориулалттай зарим төрлийн техник, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлээ.

6.Коронавируст халдвар (ковид-19)-тай тэмцэхэд Батлан хамгаалах салбар тэргүүлэн оролцож байна. Улс орны стратегийн

бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд манлайлан оролцлоо.

7.Олон улсын болон хоёр талын хамтарсан хэргийн сургуулиуд амжилттай боллоо. Батлан хамгаалах салбар ногоон хөгжлийг дэмжих, экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахад манлайлан оролцож байна.

8.Олон улсын цэргийн наадамд амжилттай оролцлоо. Цэргийн бүртгэлийг "E-Mongolia" цахим платформоор дамжуулан зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлээ.

9.Иргэний зөвлөл байгуулагдан, тусгай дугаарыг ажиллуулж эхэллээ. Түвшин тогтоох үзлэгийг зохион байгууллаа.

10.Цэргийн алба хаагчийн эр зориг, тэсвэр хатуужлыг батлан харууллаа. Батлан хамгаалах салбарын хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа шинэ шатанд гарлаа.

11.Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийг хамтран зохион байгууллаа. Цэргийн нэгтгэл, анги, салбар, байгууллагуудын зарим үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж байна.

### БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2021 ОНЫ ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

#### Нэг.Түүхэн ойнуудыг тэмдэглэв

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 250 дугаар тогтоолын дагуу Богд хаант Монгол Улсын анхны 5 яамны нэг "Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам" буюу өдгөөгийн "Батлан хамгаалах яам"-ны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэв.

Дээрх ойн хүрээнд олон улсын болон салбарын хэмжээнд эрдэм шинжилгээ, онол арга зүйн хурал, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, ойд зориулан түүхийн ном, баримтат кино, видео клип, гэрэл зургийн цомог зэргийг бүтээн олны хүртээл болгож, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний түүх, өнөөгийн үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар иргэд, олон нийтэд сурталчилсан арга хэмжээ болсон юм.



#### Хоёр. Монгол Улсын Зэвсэгт хүчин Төрийн тэргүүн зэргийн одон хүртэв

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан "...Өнгөрсөн түүхийн туршид Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, газар нутгийн халдасгүй дархан байдлыг сахин хамгаалах, Их эзэн Чингис хааны ялагдасгүй цэргийн залгамж Монгол цэргийн нэр төр, яруу алдрыг өндөрт өргөн, дэлхий нийтийн аюулгүй байдлыг хангах үйлсэд эр зориг тэсвэр тэвчээр, сахилга бат, ур чадвараар манлайлан оролцож, эх орон, төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэсэн Зэвсэгт хүчний үе үеийн ажилтан албан хаагч, цэрэг, офицер, ахлагч нарын гарамгай гавьяа, зүтгэлийг өндрөөр..." үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн "Чингис хаан" одонг хүртээсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу "Чингис хаан" одонг хүртээх ёслолын ажиллагааг 5 дугаар сарын 29-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан бөгөөд уг одонг Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний төлөөлүүлэн Зэвсэгт хүчний Жанжин штабт гардуулав.



#### Гурав. Төрлийн цэргийн удирдлагын байгууллагуудыг бэхжүүлээ

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчинд шинээр байгуулагдсан Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газарт Байлдааны тугийг гардуулах ажиллагааг ёслол хүндэтгэлтэйгээр зохион байгууллаа.

Түүнчлэн Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний

бүтэцэд тусгай хүчний цэргийн анги байгуулагдлаа. Ингэснээр тус анги бие дааж стратеги, оператив, тактикийн түвшинд тавигдсан үүргийг биелүүлэх нөхцөл бүрдэх, хамтын ажиллагаатай улс орнуудын ижил төстэй тусгай хүчний цэрэг, цэргийн анги, байгууллагатай хамтран ажиллах, сургалт, дадлага зохион байгуулах, туршлага солилцох боломжтой болсон юм.

Мөн Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын төвийн чадавх, мэргэжлийн боловсон хүчний болон техник хэрэгслийн чадамжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол бүхий "Мэдээллийн технологийг хамгаалах компьютерын халдлагад хариу үзүүлэх бүлэг байгуулах төслийг амжилттай хэрэгжүүлж 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр "Кибер аюулгүй байдлын төв"-ийг нээлээ.



#### Дөрөв. Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаа өргөжлөө

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Оросын Холбооны Улсад ажлын айлчлал хийлээ. Айлчлалын үеэр тус улсын Батлан хамгаалахын сайд, армийн генерал С.К.Шойгутай албан ёсны уулзалт хийж, хоёр талын цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал нэгдлээ.

Мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Турк Улсад ажлын айлчлал хийж, тус улсын Үндэсний Батлан хамгаалахын сайд Хулуси Акартай хамтын ажиллагааны өргөн хүрээний асуудлаар хэлэлцэн, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлолоо.

2021 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалахын сайд хурандаа генерал Вэй Фөнхэ, ОХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Батлан хамгаалахын сайдын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В.Герасимов нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь талууд батлан хамгаалахын харилцаа, хамтын ажиллагаанд өндөр ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл боллоо.

Эдгээр батлан хамгаалахын өндөр түвшний харилцан айлчлал нь Монгол Улсын энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг хангаж, олон улсад болон бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, энх тайван, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.



#### Тав. Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлын түвшнийг дээшлүүлээ

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Түргэн байрлах хүчний рот", "Инженерийн рот", "Цэргийн хэргийн II шатны эмнэлэг"-ийн үндсэн болон өөрийгөө хангах техник, тоног төхөөрөмж,

бэлэн байдал, сургалтын түвшнийг НҮБ-ын "Үнэлгээ зөвлөмжийн үзлэг"-т 2021 оны 10 дугаар сарын 07-19-ний өдрүүдэд цахим хэлбэрээр амжилттай шалгуулж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чадавхын бэлэн байдлын системийн 2 дугаар түвшинд гаргаад байна.

Улмаар "Түргэн байрлах хүчний рот"-ыг 2022 оны эхний улиралд, "Инженерийн рот"-ыг 2022 оны сүүлээр үүрэг гүйцэтгэх боломжтой гэсэн дүгнэлтийг НҮБ-ын "Үнэлгээ зөвлөмжийн үзлэг"-ийн багаас өглөө.

Мөн Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан Умард атлантын гэрээний байгууллагуудын тэргүүлсэн "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд АНУ болон ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудыг УАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоолыг үндэслэн 2021 оны 6, 7 дугаар сард амжилттай эгүүлэн татлаа. Ингэснээр тус улсад 2003 оноос эхлэн явагдсан олон улсын цэргийн ажиллагаа дахь Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцоо дуусгавар болсон юм.

Дээрхээс гадна Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж байгаа энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн зэвсэглэл, цэргийн техникийг сольж шинэчлэх зорилгоор нийт 34 нэгж авто, хуягт техникийг бүрдүүлэн, цэргийн багт тээвэрлэн хүргэх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх боломж, чадавхыг нэмэгдүүлээ.



#### Зургаа. Коронавируст халдвар (ковид-19)-тай тэмцэхэд Батлан хамгаалах салбар тэргүүлэн оролцож байна

Эрүүл мэндийн, Батлан хамгаалахын, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан 2020 оны "Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай" тушаалын дагуу Цэргийн төв эмнэлэг нь 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тусгай дэглэмд шилжиж, коронавирүсийн халдвар авсан иргэдийг хүлээн авч тусгаарлан, иргэд, үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэн өнөөг хүртэл ажиллаж байна.

Мөн Зэвсэгт хүчний дархлаажуулалтын багийн эмч, эмнэлгийн ажилтнууд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн болон нийгмийн хариуцлагын хүрээнд хүнс, худалдааны салбарын 6300, өмнөд бүсийн уул уурхайн 44 байгууллага, 113 нэгжийн 17434 ажилтан, албан хаагчдад дархлаажуулалтыг амжилттай зохион байгуулсан юм.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн дархлаажуулалтын нэгдүгээр тунд 100 хувь, хоёрдугаар тунд 98 хувь, гуравдугаар тунд 81 хувьтай хамрагдсан бөгөөд энэ нь Монгол Улсын дархлаажуулалтын дунджаас 23-56 хувиар дээгүүр байна.

#### Долоо. Олон улсын болон хоёр талын хамтарсан хэргийн сургуулиуд амжилттай боллоо

Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, дайчин нөхөрлөл, цэргийн хамтын ажиллагаанд томоохон байр суурийг эзэлдэг "Сэлэнгэ-2021" байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуулийг манай улсын нутаг дэвсгэрт 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Сургуулийг "Терроризмын эсрэг хамтарсан операцыг зохион байгуулах" сэдвийн дор явуулсан ба хоёр улсын Зэвсэгт хүчнээс 1200 гаруй цэргийн алба хаагч, 200 орчим байлдааны зэвсэг, техник оролцсон юм.

Мөн бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ОХУ-ын Зэвсэгт хүчний Баруун цэргийн тойргийн сургалтын төвд зохион байгуулсан "Запад-2021" олон улсын хамтарсан хэргийн сургууль, БНХАУ-д явагдсан олон улсын энхийг сахиулах ажиллагааны "Хамтын хувь заяа" хэргийн сургуулиудад Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид амжилттай оролцлоо.

#### Найм. Олон улсын цэргийн наадамд амжилттай оролцлоо

ОХУ-д зохион байгуулагдсан "Аравт" морин цэргийн уралдаан, "Танкийн биатлон" болон "Цэргийн авто ралли" тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид амжилттай оролцлоо. Энэ удаагийн "Аравт" олон улсын морин цэргийн уралдаанд манай улсын баг, тамирчид дэд байрт шалгарсан юм.

Мөн "Танкийн биатлон" болон "Цэргийн ралли" тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг, тамирчид амжилттай оролцож 5 дугаар байрт шалгарсан бөгөөд уг тэмцээний зарим төрөлд манай тамирчид 8 медаль хүртсэн амжилтыг үзүүлээ.



#### Ес. Иргэний зөвлөл байгуулагдан, тусгай дугаарыг ажиллуулж эхэллээ

Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Батлан хамгаалахын сайдын дэргэд "Иргэний зөвлөл"-ийг байгуулж, түүний ажиллах журмыг Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар баталгаажуулан, тус зөвлөлийг үүрэгт ажилд нь орууллаа.

Мөн Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар иргэдээс 24 цагаар санал, хүсэлт хүлээн авах "Батлан хамгаалах-иргэний хяналт 1800-1144" тусгай дугаарыг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс ажиллуулж эхлээд байна.

Энэхүү тусгай дугаар нь иргэдийг сонсох, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт тавихад тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, иргэд өөрийн санал, хүсэлт, гомдол, мэдээллээ цаг алдахгүй шуурхай гаргаж, шийдвэрлүүлэх тогтолцоог бий болгох, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэх чухал ач холбогдолтой юм.



# БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2021 ОНЫ ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ, БҮТЭЭЛЧ АЖЛУУД

## Арваннэг. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг хамтран зохион байгууллаа

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилсан Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолын дагуу Батлан хамгаалах яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб хамтран хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төв, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа “Шархад” дахь Сургалтын төв, олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт нийт 2389 залуусыг хүлээн авч сургалтад хамрууллаа.

Хөдөлмөрийн насны залуусыг “Оролцоо” төсөлд хамруулснаар тэдний хандлага, ёс суртахуун, зан төлөвт эерэг нөлөөлөл үзүүлж, цаашид бие даан ажил, мэргэжлийн чиг баримжаагаа зөв олох, амьдралын гараагаа зөв эхлүүлэх, эрүүл зөв амьдралын хэв маягт шилжихэд үнэтэй хувь нэмэр оруулсан ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.



## БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2021 ОНЫ БҮТЭЭЛЧ АЖЛУУД

### Нэг. Батлан хамгаалахын хууль, эрх зүйн шинэчлэл хийгдэж байна

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны ээлжит хуралдаанаар Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн боллоо.

Хуулийн өөрчлөлтийн хүрээнд Тагнуулын ерөнхий газрын бүтэцээс цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний Жанжин штабын мэдэлд шилжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол Улсын Зэвсэгт хүчин тайван болон дайны цагт цэргийн тагнуулын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд, улс орны хэмжээнд үүссэн цагийн байдалд нийцүүлж явуулах нөхцөл хангагдах ач холбогдолтой юм.

Мөн “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэн батлуулаа. Хууль батлагдсанаар хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын алба хаагчид, тэр дундаа эмэгтэй цэргийн алба хаагчидтай холбоотой эрх зүйн байдал, нийгмийн баталгаа сайжрах болно.

Түүнчлэн Газрын төлбөрийн тухай хууль, Гаалийн тухай болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

### Хоёр. Журмууд шинэчлэгдэн батлагдлаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэрээр байгуулагдсан “Цэргийн цол олгох журам”-ыг шинэчлэх ажлын хэсэг цэргийн цолны хэрэглээний нөхцөл байдал, цолны үнэлэмж, зохицотой харьцаа зэрэгт судалгаа хийсний үндсэн дээр тус журмыг боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 136 дугаар зарлигаар баталгаажууллаа.

“Цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, хангах, хадгалах журам”, “Цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг экспортлох, импортлох журам”-ыг Засгийн газрын 2021 оны 337 дугаар тогтоолоор батлууллаа.

Журмууд хэрэгжсэнээр цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх болон экспортлох, импортлох, хангах, хадгалахтай холбогдсон зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх албан тушаалтны эрх, үүрэг тодорхой болж, хуулийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдлээ.

Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/31 дүгээр тушаалаар “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам”, “Энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэлийг зохион байгуулах, ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам”-ыг батлуулж, Захираганы хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээ.

Ингэснээр Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох болон ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл, ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, ажиллагааны дараах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчин улам нарийвчлан зохицуулагдаж, ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн баг, цэргийн алба хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

Дээрхээс гадна “Цэргийн мэргэжлийн зэрэг олгох журам”, “ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/75, А/113 дугаар тушаалуудаар шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна.

### Гурав. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний дунд хугацааны хөгжлийн стратегийн баримт бичгүүд батлагдлаа

Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/62 дугаар тушаалаар “Батлан хамгаалахын стратеги төлөвлөгөө”-г батлуулж, салбарын дунд хугацааны зорилт, түүнийг

хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга зам, хүрэх үр дүнг тодорхойлолоо.

Мөн “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын 2021 оны 19 дүгээр хуралдаанд танилцуулж, уг хуралдааны тэмдэглэлийн дагуу тус төлөвлөгөөг Батлан хамгаалахын сайдын 2021 оны тушаалаар баталгаажуулан хэрэгжилтийг хангаж байна.

Уг төлөвлөгөөнд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн, чадварлаг болгох, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлж, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх гэсэн зорилгын хүрээнд 7 зорилтыг дэвшүүлж, нийт 53 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх юм.

### Дөрөв. Батлан хамгаалахын “ЦАГААН НОМ”-ыг бүтээлээ

“Батлан хамгаалахын цагаан ном”-ыг шинэчлэн бүтээж, олны хүртээл болгоход бэлэн болоод байна.

Ингэснээр батлан хамгаалах бодлогын үзэл санааг гадаад улсуудад сурталчлан таниулах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, иргэн-цэргийн харилцааг хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилгод нийцүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэддээ нээлттэй, ил тод таниулах боломжтой болж байгаа юм.

### Тав. Цэргийн зориулалттай зарим төрлийн техник, тоног төхөөрөмжийг үйлдвэрлээ

Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний Туршилт, судалгааны төвүүдийг түшиглэн, тэдгээрийг чадавхжуулж, батлан хамгаалахын аж үйлдвэрийн суурийг амжилттай тавьснаар батлан хамгаалах эрх ашигт нийцсэн цэргийн зориулалттай зарим техник, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэж эхэллээ.

Үүний үр дүнд тусгай зориулалтын хөнгөн хуягласан жижиг бүлгийн байлдааны машин -12 нэгж, тагнуул-дайралтын машин-10 нэгж, хөнгөн хуягласан байлдааны машин-3 нэгж техник, орон зайн тандалт, агаарын тагнуулын зориулалт бүхий загварын нисгэгчгүй нисэх төхөөрөмж 3 нэгж, богино долгионы дунд чадлын радиостанцын анхны загварыг шинээр амжилттай бүтээгээд байна.

Эдгээр судалгаа-туршилтын арга хэмжээг хэрэгжүүлснээр батлан хамгаалах аж үйлдвэрийн суурь тавигдах, цэргийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, Зэвсэгт хүчний тусгай хүчний анги, салбаруудын гал, маневрын боломж нэмэгдэх, гаднын худалдан авалтыг багасгаж, эх орондоо нэмүү өртөг шингээсэн техник, технологийг хөгжүүлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

Мөн БХЯ-ны харьяа Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ, Туркийн Үндэсний Батлан хамгаалах яамны харьяа “МКЕ” ТӨК хооронд “Галт хэрэглэлийн үйлдвэрийн шугам байгуулах тухай” гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан нь сумны үйлдвэр байгуулах асуудлыг дахин нэг шат ахиулж чадсан чухал арга хэмжээ болсон.

### Зургаа. Улс орны стратегийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд манлайлан оролцлоо

Зэвсэгт хүчний алба хаагчид Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 км төмөр замын далангийн суурийн ажлыг дуусгаж, дээд суурийн тодорхой хэсгийг байгуулж, “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн ажилчдын 5 блок барилга, бусад байгууламжийг барих, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын ажилд оролцож, улс орны хэмжээнд ургац хураалтын ажилд 2300 гаруй цэргийн алба хаагчийг оролцуулж, “Тавантолгой түлш” ТӨҮГ-ын түүхий эдийг тээвэрлэх ажилд 190 орчим цэргийн алба хаагч, 58 нэгж өөрөө буулгагч автомашиныг үүрэг гүйцэтгүүлэн улс орны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Зэвсэгт хүчин үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгааг илтгэсэн чухал арга хэмжээ болсон.

Түүнчлэн улсын хилийн боомт дээр үүссэн нөхцөл байдлыг арилгах үүднээс Зэвсэгт хүчний 150 дугаар ангиас 50 гаруй, 336 дугаар ангиас 200 гаруй алба хаагч түүхий эд, бараа материалыг ачих буулгах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналт, журам сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүллээ.



### Долоо. Батлан хамгаалах салбар ногоон хөгжлийг дэмжих, экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахад манлайлан оролцож байна

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар нэгдэж, цөлжилттэй тэмцэх, экологийн үйлсэд Зэвсэгт хүчний алба хаагчдыг оролцуулж, 2030 он гэхэд 22 сая гаруй модыг тарьж ургуулахаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Үүний хүрээнд төмөр замын чиглэлийн дагуу элсний нүүдлээс хамгаалах ойн зурвас, авто замын дагуу ногоон зурвас, тодорхой байршилд мод үржүүлгийн газар байгуулах, ойг нөхөн сэргээх, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад мод тарих, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зэргийг хэрэгжүүлэх юм.

Түүнчлэн “Хөвсгөл нуур”-ын экосистемийг

хамгаалах, тэнцвэржүүлэх, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх бохирдлыг бууруулах зорилгоор 1985 онд живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаанд Зэвсэгт хүчнээс мэргэжлийн алба хаагчид, техник хэрэгслийг 2021 оны 8-11 дүгээр сард оролцуулан үүрэг амжилттай гүйцэтгэлээ.

Мөн энэ онд Нийслэлийн ЗДТГ-тай хамтарч нийслэлийн ногоон байгууламжийг түймрийн аюулаас хамгаалах халз зурвасыг шинэчлэн сэргээх болон байгальд мод суулгах ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг оролцуулж, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд “Жишиг ногоон байгууламжтай анги” байгуулах төслийн эхлэлийг Зэвсэгт хүчний 015 дугаар ангид амжилттай хэрэгжүүлж чадлаа.



### Найм. Цэргийн бүртгэлийг “E-Mongolia” цахим платформоор зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлээ

Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд цэргийн бүртгэлийг “E-Mongolia” нэгдсэн цонхонд байршуулах асуудлыг нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн төв болон Дата төвтэй хамтран шийдвэрлээ.

Цэргийн бүртгэлийг “E-Mongolia” нэгдсэн цонхонд байршуулж иргэдийг цахим орчинд саадгүй нэвтрэх боломжийг нээж өгснөөр иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэх ач холбогдолтой болсон юм.



### Ес. Түвшин тогтоох үзлэгийг зохион байгуулав

БХЯ, ЗХХЖЗ, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, тэдгээрийн харьяа байгууллага, нэгтгэл, анги, салбаруудын офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэгийг 2021 оны 5 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Энэхүү үзлэгийг офицер, ахлагч нарын мэргэшил, үр чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэгт бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг тогтоох, цаашид цэргийн алба хаагчдыг хөгжүүлэх, цэргийн албыг бэхжүүлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор явуулсан нь үр дүнтэй ажил боллоо.

## БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭС 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ

1. “Цэргийн албаны тухай”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулла.
2. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний дунд хугацааны хөгжлийн баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
3. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө болон Зэвсэгт хүчний стратеги, цэргийн дайчилгааны удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг шинэчлэн, хэрэгжилтийг зохион байгуулна.
4. Батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааныг 2030 он хүртэл хөгжүүлэх бодлогын хүрээнд батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн, цэргийн зориулалттай зарим бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, зэвсэглэлд нэвтрүүлнэ.
5. “Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г баталгаажуулж, хэрэгжилтийг хангаж эхэлнэ.
6. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх чиглэлээр дээд, дунд хэмжээний харилцан айлчлалыг зохион байгуулж, олон улсын сургалт уралдаан, цэргийн мэргэжлийн зорилгоор Зэвсэгт хүчний алба хаагчдыг оролцуулна.
7. Монгол Улсын Зэвсэгт хүчин Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн цэргийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.
8. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах “Түргэн байрлах хүчний рот”, “Инженерийн рот”, “Цэргийн хэрийн II шатны эмнэлэг”-ийн бэлтгэлийг хангаж, зарим нэгжийг оролцуулж эхэлнэ.
9. Кибер аюулгүй байдлын Зэвсэгт хүчний “Дата төв”-ийн

## Арав. Батлан хамгаалах салбарын хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа шинэ шатанд гарлаа

Батлан хамгаалах салбарт хэвлэл мэдээллийн оновчтой менежментийг хэрэгжүүлж, “Соёмбо-Мэдээ”, “Соёмбо-Фото”, “Дуулга-Ньюс” зэрэг шинэ платформуудыг хөгжүүлэн мэдээллийн шуурхай байдлыг хангаж, салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож, дата санг бүрдүүлээд байна.

Ингэснээр Төрийн батлан хамгаалах бодлого, зорилтыг цахимаар дамжуулан тасралтгүй, шуурхай болон шууд дамжуулан хүргэх нөхцөл бүрдэж, мэдээллийг боловсруулах, сурталчлах арга хэлбэр, нэр төрөл, сувгийн тоо нэмэгдэн, мэдээллийн цар хүрээ, далайц, эрчим, давтамж дээшилж, нэвтрүүлэг, нийтлэлийн чанар, хүртээмж улам сайжирлаа.



## Арваннэг. Цэргийн нэгтгэл, анги, салбар, байгууллагуудын зарим үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжлээ

Мэдээллийн техник, технологийн дэвшлийг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, байгууллагуудад нэвтрүүлж, цахимаар хурал, уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулахын зэрэгцээ цэргийн сургалт бэлтгэл, команд штабын сургууль, дадлагыг цахим хэлбэрээр явуулах боломжийг бүрдүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд мэдээллийн техник хэрэгслийг өргөнөөр ашиглаж байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчний хугацаат цэргийн алба хаагчидтай нэгтгэл, ангуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах үүднээс цэргийн байр, танхим, шаардлагатай барилга, байгууламжийг бүрэн камержуулж, дэлгэцийн хяналтыг тогтмол хийх боломжтой болголоо.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг бүрэн камержуулснаар цэргийн алба, сахилга зохион байгуулалт, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэж, хяналтыг сайжруулсан нь үр дүнгээ өгсөн өндөр ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

